



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2019 05 29 № 05/4411
танай 2019 05 28 -ны № 01/1587 -т

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ДЭД ДАРГА
Б.ЗАЯАБАЛ ТАНАА

Нэр ний гаргагч
Б.Заяабал
2019/05/28

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийг хянасан тухай

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн дараах нэр дэвшигчдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно. Үүнд:

1. Татварын ерөнхий газрын Мэдээлэл технологийн төвийн татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Мягмарсүрэнгийн Чойжилсүрэн,
2. Татварын ерөнхий газрын харъяа Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн Захиргааны тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Шижээгийн Нямаа,
3. Татварын ерөнхий газрын харъяа Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн Татварын орлогын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Чипагийн Жамьяансүрэн.

Нэр дэвшигчид нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж уг хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гарган ажиллах нь зүйтэй.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Х.ХАШБААТАР